

# Хоёр массивын элементүүдийг сэлгэх

$N$  ширхэг элементтэй  $A$ ,  $B$  массивуудыг авч үзье.  $A$  массивын элементүүдийг дотор нь, мөн мөн  $B$  массивын элементүүдийг дотор нь сэлгэн байрыг өөрчилсний дүнд  $A'$ ,  $B'$  массивуудыг дараах нөхцөлтэйгээр үүсгэж болох эсэхийг тооцоолох шаардлагатай болсон. Өөрөөр хэлбэл:  $A'[i]+B'[i] \geq K$  буюу үүссэн хоёр массивын харгалзах элемент бүрийн нийлбэр нь өгөгдсөн  $K$  тооноос бүгд их байхаар үүсч болох эсэхийг тогтоохыг зорьж байгаа.

Жишээлбэл:  $A=[0,1]$ ,  $B=[0,2]$   $K=1$  гэж өгөгдсөн гэвэл  $A'=[0,1]$ ,  $B'=[2,0]$  гэж үүсгэвэл  $0+2 \geq 1$ ,  $1+0 \geq 1$  буюу ийм байдлаар үүсгэж болж байгаа нь харагдаж байна.

Тэгвэл чамд  $N$  ширхэг элемент бүхий ижил урттай  $A$ ,  $B$  массивуудаас тогтох  $Q$  ширхэг асуулга бүхий тестүүд өгөгдсөн бол тэдгээр асуулга бүрд тухайн массивын элементүүдийг сэлгэн дээрх нөхцөлийг хангах  $A'$ ,  $B'$  массивыг үүсгэж болж байвал YES, үгүй бол NO гэж хэвлэнэ үү.

## Оролтын хэлбэр:

Эхний мөрөнд асуулгын тоо  $Q$  тоо өгөгдөнө.

Асуулга бүр нь дараах 3 хэсгээс бүрдэнэ.

- $N$ ,  $K$  тоонууд асуулгын эхний мөрөнд өгөгдөнө.
- Асуулгын хоёрдугаар мөрөнд  $A$  массивын элементүүд
- Асуулгын гуравдугаар мөрөнд  $B$  массивын элементүүд болох  $N$  ширхэг тоонууд тус тус зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

## Хязгаарлалт:

$$1 \leq Q \leq 10$$

$$1 \leq N \leq 1000$$

$$1 \leq k \leq 10^9 \text{ (10-ийн 9 зэрэгт)}$$

$$0 \leq A[i], B[i] \leq 10^9$$

## Гаралтын хэлбэр:

Асуулга бүрд харгалзах YES, эсвэл NO гэсэн хариултыг тус бүр шинэ мөрөнд хэвлэнэ.

## Жишээ Оролт

2

3 10

2 1 3

7 8 9

4 5

1 2 2 1

3 3 3 4

## Жишээ Гаралт

YES

NO

**Тайлбар:**

Эхний асуулгын хувьд:

$N=3$ ,  $A=[2, 1, 3]$ ,  $B=[7, 8, 9]$ ,  $K=10$  байна. Тэгвэл  $A'=[1,2,3]$   $B'=[9,8,7]$  гэж үүсгэвэл

$1+9 \geq K$ ,  $2+8 \geq K$ ,  $3+7 \geq K$  гэсэн нөхцөлийг хангаж байгаа тул YES гэж хэвлэсэн байна.

Хоёрдугаар асуулгын хувьд:

$N=4$   $K=5$   $A=[1, 2, 2, 1]$   $B=[3, 3, 3, 4]$  байгаа тул B массивын 3 тооны ядаж аль нэг дээр A массивын 1 гэсэн тоо нэмэгдэж 4 болох нь гарцаагүй учраас бүх нийлбэр өгсөн нөхцөлийг хангаж чадахгүй болох нь харагдаж байгаа учраас NO гэсэн хариултыг хэвлэж байна.

**Орчуулсан : Хөвсгөл аймгийн Ирээдүй сургуулийн багш Д.Батмөнх**